

**ТЕЛЕВИЗ, ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН
ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ЗӨВШӨӨРӨЛТЭЙ БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТЫГ ИЛ ТОД
БАЙРШУУЛАХ WWW.COPYRIGHT.CRC.GOV.MN СИСТЕМИЙН АШИГЛАЛТ,
ХЭРЭГЖИЛТИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН**

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар олгогдсон бүрэн эрх, чиг үүрэг, өргөн нэвтрүүлгийн салбарт төрөөс баримтлах бодлого, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохицуулалт хийж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахтай холбоотой үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.

Зохиогчийн эрхийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1-д “... өргөн нэвтрүүлгийн байгууллага, олон сувгийн дамжуулагч нь өөрийн болон бусад сервер, сүлжээ, санд зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөрчил гаргахгүй байх, зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийг эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангах үүрэгтэй” гэж, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-д “Өөрийн болон зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй бүтээл дамжуулна” гэж тус тус заасны дагуу тус Хорооноос “Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн өөрийн бүтээлийн болон зохиогчийн эрхтэй авсан гадаад, дотоодын контентын бүртгэлийн сан”-г <https://copyright.crc.gov.mn/> үүсгэн, 2023 оны 11 дүгээр сараас ашиглалтад оруулаж хэрэгжилтийн хангуулах чиглэлээр шат дараатай арга хэмжээ авч ажиллаж байна.

Тус хорооноос уг системийн ашиглалт, хэрэгжилтийн байдлыг хагас жил тутам тайлагнаж байгаа ба 2025 жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг дахин гаргахад дараах байдалтай байна.

1. Системд бүтээл оруулсан үйлчилгээ эрхлэгчдийн болон бүтээлийн мэдээлэл

Хүснэгт 1. Системд бүтээл оруулсан үйлчилгээ эрхлэгчдийн тоон мэдээ

Өөрийн бүтээл		
<i>Үйлчилгээ төрөл</i>	<i>ТВ тоо</i>	<i>Үйлчилгээ эрхлэгчдийн нэр</i>
ӨНТВ	11	Про медиа нетворк ХХК, Юнайтед бродкастинг корпорэйшн ХХК, Монгол телевиз ХХК, Суваг ти ви найм ХХК, АЭ энд Жааг ХХК, Медиа боловсрол суваг ХХК, Эн Ти Ви Бродкастинг ХХК, Медиа холдинг ХХК, Ийгл Бродкастинг ХХК, Чаннел-Уан ХХК, Улаанбаатар телевиз ХХК
АрТВ	8	Масс Ти Ви ХХК, Нэйшнл ньюс корпорэйшн ХХК, Хатрек ХХК, Мөрөөдлийн суваг ТББ, Эм Ди Энтертэйнмент ХХК, Лакс ТВ Монгол ХХК, Маст технологи ХХК, Монсват нэтворк ХХК
ОнТВ	11	Мэдээллийн бирж, Фило ХХК, Мичид Ньюс ХХК, Хас-Өрлөг ТББ, Ар Би Эм Ти ХХК, Шинэ зураг ХХК, Очир Арвай төв ХХК, Очир роуд ХХК, Ашдын нөхөр ХХК, Ай Жи Би Ти Виз ХХК, Хоса ТВ
ОСДҮЭ	3	Юнивишн ХХК, Мобинет ХХК, ДДэш ТВ ХХК,
НИЙТ	31	

Дотоод бүтээл		
Үйлчилгээ төрөл	ТВ тоо	Үйлчилгээ эрхлэгчдийн нэр
ӨНТВ	5	Юнайтед бродкастинг корпорэйшн ХХК, Малчин удмын хийморь ХХК, Суваг ти ви найм ХХК, Чаннел-Уан ХХК, Эн Ти Ви Бродкастинг ХХК
АрТВ	3	Масс Ти Ви ХХК, Трионикс мета вишн ХХК, Эм Ви Эс ХХК
ОнТВ	3	Фило ХХК, Ай Жи Би Ти Виз ХХК, Мичид Ньюс ХХК
ОСДҮЭ	4	МЦХ ХК, ДДэш ТВ ХХК, Ори медиа ХХК, Эн Би Си ХХК
	15	
Гадаад бүтээл		
Үйлчилгээ төрөл	ТВ тоо	Үйлчилгээ эрхлэгчдийн нэр
ӨНТВ	6	Тэнгэрлэг эх орон ХХК, Юнайтед бродкастинг корпорэйшн ХХК, Гэгээн далай ХХК, Эн Ти Ви Бродкастинг ХХК, Чаннел-Уан ХХК, Ийгл Бродкастинг ХХК
АрТВ	4	Масс Ти Ви ХХК, Трионикс мета вишн ХХК, Эм Ви Эс ХХК, Нэйшнл ньюз корпорэйшн ХХК
ОнТВ	1	Фило ХХК
ОСДҮЭ	5	МЦХ ХК, Мобинет ХХК, Шинэ сансар ХХК, Эн Би Си ХХК, Монсват нэвтворкс ХХК
	16	
Гадаад суваг		
Үйлчилгээ төрөл	ТВ тоо	Үйлчилгээ эрхлэгчдийн нэр
ОСДҮЭ	5	Юнивишн ХХК, Ддэш тв ХХК, Шинэ сансар ХХК, Эн Би Си ХХК,, МЦХ ХК

Тус системийн 2024 оны жилийн эцсийн тайланг 2025 оны хагас жилийн тайлантай харьцуулахад өөрийн бүтээлийн мэдээллийг шинээр 1 үйлчилгээ эрхлэгч буюу Хоса ТВ ХХК бүтээлээ оруулсан бол Чаннел-Уан ХХК бүтээлээ нэмж оруулжээ. Харин бусад бүтээлийн хувьд шинээр нэмэгдсэн бүтээл байхгүй байна.

График 1. 2024 оны эхний хагас жил болон сүүлийн хагас жилийн бүтээлийн тоог харьцуулсан байдал



Системд бүтээлийн мэдээллээ оруулсан үйлчилгээ эрхлэгчдийг үйлчилгээний төрлөөр нь авч үзэхэд Монгол Улсад хамрах хүрээтэй өргөн нэвтрүүлгийн телевизийн 13 үйлчилгээ эрхлэгч 897 бүтээл, арилжааны телевизийн 8 үйлчилгээ эрхлэгч 261 бүтээл, орон нутагт үйлчилгээ эрхлэгч 11 телевиз 628 төрлийн бүтээл, олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгч 10

байгууллага 1023 бүтээлүүдийг тус тус бүртгүүлсэн. Төлбөртэй телевизийн үйлчилгээ эрхлэгчид нь ямар нэгэн бүтээл бүртгүүлээгүй байна.

Хүснэгт 2. Бүтээлийн мэдээллээ оруулсан үйлчилгээ эрхлэгчдийн үйлчилгээ төрлөөр

	ӨнТВ	АрТВ	ОнТВ	ОСДҮЭ
Өөрийн бүтээл	291	65	279	84
Дотоод бүтээл	233	75	104	75
Гадаад бүтээл	373	121	245	864
Нийт	897	261	628	1023


Хүснэгт 3. Үйлчилгээ эрхлэгч тус бүрээр оруулсан бүтээл, тоогоор

№	Үйлчилгээ эрхлэгч	Өөрийн бүтээл	Дотоод бүтээл	Гадаад бүтээл
1	Юнивишн ХХК	24		
2	Мобинет ХХК	33	51	279
3	Чаннел-Уан ХХК	51	1	23
4	Масс Ти Ви ХХК	6	4	8
5	Монгол телевиз ХХК	6		
6	Нэйшнл ньюс корпорэйшн ХХК	16		5
7	Суваг ти ви найм ХХК	3	3	3
8	Асгатын гол ХХК	10		
9	Эн Ти Ви Бродкастинг ХХК	3	31	94
10	Медиа боловсрол суваг ХХК	85		
11	АЭ энд Жааг ХХК	35		
12	Фило ХХК	25	90	245
13	Хатрек ХХК	5		
14	Медиа холдинг ХХК	7		2
15	Юнайтед бродкастинг корпорэйшн ХХК	67	97	15
16	Ай Жи Би Ти Виз ХХК	10	10	
17	Мичид Ньюс ХХК	18	4	
18	Мөрөөдлийн суваг ТББ	22		
19	Хас-Өрлөг ТББ	7		
20	Ар Би Эм Ти ХХК	4		
21	Маст технологи ХХК	7		
22	Шинэ зураг ХХК	1		
23	Эм Ди Энтертэймент ХХК	2		
24	Очир Арвай төв ХХК	151		
25	Лакс ТВ Монгол ХХК-натур хаан ххк	7		
26	Ийгл Бродкастинг ХХК	19		19
27	Очир роуд ХХК	1		
28	Ашдын нөхөр ХХК	31		
29	Улаанбаатар телевиз ХХК	6		

30	Про медиа нетворк ХХК	9		
31	ДДэш ТВ ХХК	27	8	
32	Эн Би Си ХХК		1	108
33	Малчин удмын хийморь		101	
34	Трионикс мета вишн ХХК		12	60
35	Эм Ви Эс ХХК			38
36	Монголын цахилгаан холбоо ХК		15	5
37	Гэгээн далай ХХК			12
38	Тэнгэрлэг эх орон ХХК			238
39	Монвсат нэтворк ХХК			213
40	Монголсат нэтворкс ХХК			105
41	Шинэ сансар ХХК			131
42	Хоса тв ХХК	21		
Нийт		720	487	1603

Системд бүртгүүлсэн үйлчилгээ эрхлэгчдээс Юнайтед бродкастинг корпорэйшн ХХК-ийн Стар, Чаннел-Уан ХХК-ийн С1, Суваг ти ви найм ХХК-ийн ТВ8, Эн Ти Ви Бродкастинг ХХК-ийн NTV зэрэг өргөн нэвтрүүлгийн телевизүүд, Масс Ти Ви ХХК-ийн Масс арилжааны телевиз, Орон нутгийн өргөн нэвтрүүлгийн Фило ХХК-ийн ТВ24 телевиз, ОСДҮЭ-ээс Мобинет ХХК, Эн Би Си ХХК зэрэг үйлчилгээ эрхлэгч өөрийн бүтээл, дотоодын болон гадаадын бүтээлийн ангилал тус бүрээр бэлтгэн оруулсан байна.

График 2. Үйлчилгээ эрхлэгч тус бүрээр оруулсан нийт бүтээлийн тоон мэдээлэл



2. Системд оруулсан Өөрийн болон дотоод бүтээлийн мэдээлэл

Өөрийн бүтээл системд оруулсан 32 үйлчилгээ эрхлэгчээс Чаннел Уан ХХК 2024 оны жилийн эцсээр 30 бүтээл оруулсан бол 2025 оны хагас жилээр 51 болж нэмэгдүүлсэн, Хоса ТВ ХХК нь шинээр 21 бүтээл оруулсан байна.

Хүснэгт 4. Үйлчилгээ эрхлэгчдийг системд бүртгүүлсэн өөрийн бүтээлийг авч үзэхэд, тоогоор

Үйлчилгээ эрхлэгчийн нэр	Юнивишн ХХК	Мобинет ХХК	Чаннел-Уан ХХК	Масс Ти Ви ХХК	Монгол телевиз ХХК	Нэйшл ньос корпорэйшн ХХК	Суваг ти ви найм ХХК	Асгатын гол ХХК	Эн ти ви бродкастинг ХХК	Медиа боловсрол суваг ХХК	АЭ энд Жааг ХХК	Фило ХХК	Хатрек ХХК	Медиа холдинг ХХК	Юнайтед бродкастинг корпорэйшн ХХК	Ай жи би ти виз ХХК	Мичид ньос ХХК	Мөрөөдлийн суваг ХХК	Хас-Өрлөг ХХК	Ар Би Эм Ти ХХК	Маст технологи ХХК	Шинэ зураг ХХК	Эм ди энтертаймент ХХК	Очир Арвай ХХК	Лакс тв Монголиа ХХК	Ийгл бродкастинг ХХК	Ояир роуд ХХК	Ашдын нөхөр ХХК	Улаанбаатар телевиз ХХК	Про медиа нетворк ХХК	ДДэш ТВ ХХК	Хоса тв	Монсват нетворк
Системд бүртгүүлсэн өөрийн бүтээл	24	33	51	6	6	16	3	10	3	85	35	25	5	7	67	10	18	22	7	4	7	1	2	151	7	19	1	31	6	9	27	21	1

Дотоод бүтээл оруулсан үйлчилгээ эрхлэгчдээс Ай Жи Би Ти Виз ХХК-ийн RGB телевиз хагас жилээр 7 бүтээл оруулсан байсан бол жилийн эцсийн байдлаар 10 бүтээл, Мичид Ньюс ХХК-ийн Тамир телевиз нь 4 бүтээлээс 18 бүтээл, Фило ХХК-ийн ТВ24 нь 25 бүтээлээс 93 бүтээл, Эн Ти Ви Бродкастинг ХХК-ийн NTV телевиз нь 3 бүтээлээс 31 бүтээл, Юнайтед бродкастинг корпорэйшн ХХК-ийн Стар телевиз нь 67 бүтээлээс 97 бүтээл болгон тус тус нэмэгдүүлжээ. ОСДҮЭ-ээс Монголын цахилгаан холбоо ХК шинээр 15 бүтээл нэмж бүртгүүлсэн байна.

Хүснэгт 5. Үйлчилгээ эрхлэгчдийг системд бүртгүүлсэн дотоод бүтээлийг авч үзэхэд, тоогоор

Үйлчилгээ эрхлэгчийн нэр	Мобинет ХХК	Чаннел-Уан ХХК	Масс Ти Ви ХХК	Суваг ти ви найм ХХК	Эн Ти Ви Бродкастинг ХХК	Фило ХХК	Юнайтед бродкастинг корпорэйшн ХХК	Ай Жи Би Ти Виз ХХК	Мичид Ньюс ХХК	Малчин удмын хийморь ХХК	Трионикс мета вишн ХХК	Эм Ви Эс ХХК	Монголын цахилгаан холбоо ХК	ДДэш ТВ ХХК	Эн Би Си ХХК	Нийт
Системд бүртгүүлсэн өөрийн бүтээл	51	1	4	3	31	90	97	10	4	101	12	59	15	8	1	487

Хүснэгт 6. Хөтөлбөрийн төрөл жанраар үйлчилгээ эрхлэгч нэг бүрээр авч үзэхэд /Өөрийн болон дотоод бүтээл/


№	Үйлчилгээ эрхлэгчийн нэр	Уран Сайхны кино	Олон ангит кино	Баримтат кино	Хүүхэлдэйн кино	Олон ангит хүүхэлдэйн кино	Нэвтрүүлэг	Богино хэмжээний кино	Бусад	Нийт
1	Юнивишн ХХК	14	8	1		1				
2	Мобинет ХХК		21				12			

3	Чаннел-Уан ХХК				1	46			
4	Масс Ти Ви ХХК					10			
5	Монгол телевиз ХХК					6			
6	Нэйшнл ньус корпорэйшн ХХК					16			
7	Суваг ти ви найм ХХК	3				3			
8	Асгатын гол ХХК					10			
9	Эн Ти Ви Бродкастинг ХХК	28	1			25			
10	Медиа боловсрол суваг ХХК		9			76			
11	АЭ энд Жааг ХХК		1	1		32	1		
12	Фило ХХК	46		17	14	41			
13	Хатрек ХХК					4	1		
14	Медиа холдинг ХХК					7			
15	Юнайтед бродкастинг корпорэйшн ХХК							164	
16	Ай Жи Би Ти Виз ХХК					17			
17	Мичид Ньюс ХХК					26			
18	Мөрөөдлийн суваг ТББ				1	20	1		
19	Хас-Өрлөг ТББ			2		5			
20	Ар Би Эм Ти ХХК					4			
21	Маст технологи ХХК					71			
22	Шинэ зураг ХХК					1			
23	Эм Ди Энтертэйнмент ХХК					2			
24	Очир Арвай төв ХХК				1	150			
25	Лакс ТВ Монгол ХХК-натур хаан ххк					7			
27	Ийгл Бродкастинг ХХК					18	1		
28	Очир роуд ХХК					1			
29	Ашдын нөхөр ХХК			8		23			
30	Улаанбаатар телевиз ХХК	4	2						
31	Малчин удмын хийморь ХХК	96	1			2	1		
32	Тэнгэрлэг эх орон ХХК					9			
33	ДДэш тв ХХК	34				1			
34	Эн Би Си ХХК	1				21			
35	Ори медиа ХХК	49	2						
36	Эм Ви Эс ХХК	59							
37	Монголын цахилгаан холбоо ХК	15							
38	Трионикс мета вишн ХХК	12							

Өөрийн болон дотоод бүтээлийг төрөл жанраар ангилан авч үзэхэд “нэвтрүүлэг” төрлийн бүтээлийг хамгийн их оруулсан бөгөөд нийт 38 үйлчилгээ эрхлэгчээс 31 нь уг төрөлд бүтээл оруулсан нь нийт бүтээлийн 52%-ийг

эзэлж байна. Харин уран сайхны киног 12 үйлчилгээ эрхлэгч оруулсан нь нийт бүтээлийнх нь 28%-ийг эзэлж байна.

График 3. Хөтөлбөрийн төрөл жанрыг хувь хэмжээгээр авч үзэхэд /Өөрийн болон дотоод бүтээл/



3. Системд оруулсан гадаад бүтээлийн мэдээлэл

2024 оны жилийн эцсийн байдлаар нийт 19 үйлчилгээ эрхлэгч 1604 гадаад бүтээл оруулсан нь хагас жилийн дүнтэй харьцуулахад 590 бүтээлээр нэмэгдсэн байна. Эдгээрээс гадаад бүтээл хамгийн их оруулсан нь Орон нутгийн үйлчилгээ эрхлэгч Фило ХХК-ийн ТВ24 телевиз (245 бүтээл) бол удаах нь Тэнгэрлэг эх орон ХХК-ийн Централ телевиз (238 бүтээл) байна.

Хүснэгт 7. Үйлчилгээ эрхлэгчдийг системд бүртгүүлсэн гадаад бүтээлийг авч үзэхэд, тоогоор

Үйлчилгээ эрхлэгчийн нэр	Гэгээн далай ХХК	Мобинет ХХК	Чаннел-Уан ХХК	Масс Ти Ви ХХК	Нэйшнл ньос корпорэйшн ХХК	Суваг ти ви найм ХХК	Эн Ти Ви Бродкастинг ХХК	Фило ХХК	Медиа холдинг ХХК	Юнайтед бродкастинг корпорэйшн ХХК	Ийгл Бродкастинг ХХК	Тэнгэрлэг эх орон ХХК	Монвсат нэтворк ХХК	Монголсат нэтворкс ХХК	Монголын цахилгаан холбоо ХК	Эм Ви Эс ХХК	Трионикс мета вишн ХХК	Шинэ сансар ХХК	Эн Би Си ХХК	Нийт
Системд бүртгүүлсэн өөрийн бүтээл	12	279	23	8	5	3	94	245	2	15	19	238	213	105	5	38	60	131	108	1604

Тус системд 38 улсын нийт 1603 бүтээл оруулснаас хамгийн их нийлүүлэлт өндөртэй нь АНУ, БНСУ, БНХАУ-ын бүтээлүүд байна. Тодруулбал, АНУ-ын бүтээл 415, БНСУ-ын бүтээл 305, БНХАУ-ын бүтээл 47 бүртгэгджээ.

Хүснэгт 8: Гадаад бүтээл нийлүүлэлтийг улс тус бүрээр

№	Улсын нэр	Бүтээлийн тоо	№	Улсын нэр	Бүтээлийн тоо
1	Албаны	1	19	Монако	2
2	Австрали	16	20	Монгол	506
3	Австри	4	21	Нидерланд	2
4	Америк	415	22	Норвег	1
5	Армени	1	23	Орос	31
6	Бельги	2	24	Румын	2
7	Бразил	5	25	Сингапур	4
8	Вьетнам	2	26	Солонгос	305
9	Герман	18	27	Турк	4
10	Дани	2	28	Украйн	2
11	Иран	3	29	Филиппин	1

12	Испани	4	30	Франц	27
13	Казакстан	3	31	Хятад	47
14	Канад	5	32	Швед	2
15	Малави	1	33	Швейцар	6
16	Малайз	2	34	Шинэ Зеланд	1
17	Мексик	4	35	Энэтхэг	4
18	Япон	20			

4. ОСДҮЭ-ийн систем ашиглалтын мэдээлэл

Монгол Улсад олон суваг дамжуулах үйлчилгээг (ОСДҮ)27 байгууллага буюу Улаанбаатар хотод 12, орон нутагт 15 аж ахуйн нэгж эрхэлж байна.

Дээрх байгууллагуудаас 2025 оны хагас жилийн байдлаар давхардаагүй тоогоор 9 олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь зохиогчийн эрхийн нээлттэй систем болох www.copyright.crc.gov.mn цахим платформд зохиогчийн эрхтэй бүтээлийн мэдээллээ бүртгүүлсэн. Энэ нь нийт ОСДҮЭ-ийн 33.3%-ийг эзэлж байна. Тухайн 9 байгууллагын бүртгүүлсэн бүтээлийн ангиллыг авч үзвэл:

- Өөрийн бүтээл – 3 байгууллага
- Дотоодын бүтээл – 3 байгууллага
- Гадаад бүтээл – 5 байгууллага
- Гадаад суваг – 5 байгууллага тус тус бүртгүүлжээ.

Дээрх системд мэдээллээ оруулсан олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийг технологийн төрлөөр нь ангилан үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- IPTV технологиор үйл ажиллагаа явуулдаг – 1 байгууллага
- OTT технологиор үйл ажиллагаа эрхэлдэг – 2 байгууллага
- DVB-S2 (хиймэл дагуулаар) дамжуулалттай – 2 байгууллага
- DVB-T2 (агаараар) дамжуулах үйлчилгээ эрхэлдэг – 3 байгууллага
- DVB-C2 (кабелиар) дамжуулдаг – 1 байгууллага


Хүснэгт-1.ОСДҮЭ-ийн бүртгүүлсэн бүтээлийн төрлөөр ангилсан тоон мэдээлэл.

№	Үйлчилгээ эрхлэгчийн нэр	Өөрийн бүтээлийн	Дотоодын бүтээлийн	Гадаад бүтээл	Гадаад суваг	Нийт
1	Мобинет ХХК	33		279		312
2	Монголсат нэтворкс ХХК			105		105
3	Монголын цахилгаан холбоо ХК		15	5	5	25
4	Шинэ сансар кабель ХХК			131		131
5	Эн Би Си ХХК			108	49	157
6	Юнивишн ХХК	24			80	104

7	Сансар Дижитал ХХК				31	31
8	ДДэш ТВ ХХК	27	8		51	86
9	Ори медиа ХХК		51			51
Нийт		84	74	628	216	1002


Дээрх хүснэгтийн мэдээллээс үзэхэд, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид (ОСДҮЭ) нийт 1002 зохиогчийн эрхтэй бүтээлийн мэдээллийг www.copyright.crc.gov.mn системд бүртгүүлсэн байна. Үүнээс Мобинет ХХК нь хамгийн олон буюу 312 бүтээл бүртгүүлсэн бөгөөд энэ нь ОСДҮЭ-ийн оруулсан нийт бүртгэлтэй бүтээлийн 31 хувийг бүрдүүлсэн бол Монголын цахилгаан холбоо ХК нь хамгийн цөөн буюу 25 бүтээл бүртгүүлж, ОСДҮЭ-ийн оруулсан нийт бүтээлийн 2.5 хувийг бүрдүүлжээ.

График-1. ОСДҮЭ бүрийн бүртгүүлсэн бүтээлийн нийт дүнг хувиар илэрхийлэв.




ӨӨРИЙН БҮТЭЭЛ:

Зохиогчийн эрхийн нээлттэй систем болох www.copyright.crc.gov.mn цахим платформд зохиогчийн эрхтэй бүтээлийн мэдээлэл бүртгүүлсэн 9 олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчээс ДДэш ТВ ХХК, Мобинет ХХК, Юнивишн ХХК нь нийт 84 өөрийн бүтээл бүртгүүлсэн. Энэ нь нийт бүртгэгдсэн 719 өөрийн бүтээлийн 12%-ийг эзэлж байна.



Мобинет ХХК нь 33 өөрийн бүтээл бүртгүүлж, ОСДҮЭ-ийн бүртгүүлсэн 84 өөрийн бүтээлийн 39% эзэлж байна.



Ддэш ТВ ХХК нь 27 өөрийн бүтээл бүртгүүлж, ОСДҮЭ-ийн бүртгүүлсэн 84 өөрийн бүтээлийн 32% эзэлж байна.



Юнивишн ХХК нь 24 өөрийн бүтээл бүртгүүлж, ОСДҮЭ-ийн бүртгүүлсэн 84 өөрийн бүтээлийн 29% эзэлж байна.

№	Үйлчилгээ эрхлэгчийн нэр	Бүтээлийн төрөл					Нийт
		Нэвтрүүлэг	Олон ангит кино	Уран сайхны кино	Баримтат кино	олон ангит хүүхэлдэйн кино	
1	Мобинет ХХК	12	21				33
2	Ддэш ТВ ХХК	1		26			27
3	Юнивишн ХХК		8	14	1	1	24
Нийт		13	29	40	1	1	84

Мобинет ХХК нь зохиогчийн эрхийн нээлттэй системд нийт 33 өөрийн бүтээлийн мэдээлэл бүртгүүлсэн. Энэ нь нийт бүртгэгдсэн ОСДҮЭ-ийн өөрийн бүтээлийн 39%-ийг бүрдүүлжээ. Үүнээс 12 нь нэвтрүүлэг, 21 нь олон ангит кино байсан бөгөөд энэ нь тус байгууллага өөрийн бүтээсэн контент, ялангуяа олон ангит киноны үйлдвэрлэлд илүүтэй анхаарч буйг илтгэж байна.

Ддэш ТВ ХХК нь системд 27 бүтээл бүртгүүлсэн ба нийт ОСДҮЭ-ийн өөрийн бүтээлийн тоотой харьцуулахад 32%-ийг бүрдүүлж байна. Үүнээс 1 нь нэвтрүүлэг, үлдсэн 26 бүтээл нь уран сайхны кино байна. Тус байгууллага нь өөрийн бүтээлийн хувьд уран сайхны кинонд төвлөрсөн бөгөөд нийт бүртгэгдсэн 40 уран сайхны киноны 65%-ийг (26 бүтээл) дангаараа бүрдүүлж байна.

Юнивишн ХХК нь зохиогчийн эрхийн нээлттэй системд нийт 24 өөрийн бүтээлийн мэдээлэл бүртгүүлсэн ба нийт бүртгэгдсэн ОСДҮЭ-ийн өөрийн бүтээлийн 29%-ийг бүрдүүлж байна. Үүнээс баримтат кино-1, олон ангит кино-8, уран сайхны кино-14, олон ангит хүүхэлдэйн кино-1 бүртгэгджээ. Эдгээрээс харахад Юнивишн ХХК нь контентын төрлийн хувьд хамгийн олон төрөл бүхий бүтээл бүртгүүлсэн байгууллага бөгөөд нийт таван ангиллаас дөрвөн төрөл


(нэвтрүүлгээс бусад) багтсан нь контент хөгжүүлэлтдээ төрөлжүүлэлтийг чухалчилж буйг илтгэж байна.

ДОТООД БҮТЭЭЛ:

Системд нийт 487 дотоод бүтээл бүртгэгдсэнээс 3 олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч болох ДДэш ТВ ХХК, Монголын цахилгаан холбоо ХК, Ори медиа ХХК-ийн 74 бүтээлийн мэдээлэл бүртгэгдсэн нь нийт дотоод бүтээлийн 15%-ийг эзэлж байна.

- ДДэш ТВ ХХК нь 8 уран сайхны кино бүртгүүлсэн бөгөөд энэ нь дээрх гурван үйлчилгээ эрхлэгчийн бүртгүүлсэн бүтээлийн 11%-ийг эзэлжээ. Бүртгүүлсэн бүх бүтээлийн эрхийн гэрээ хугацаагүйгээр байгуулагдсан байна.
- Монголын цахилгаан холбоо ХК (МЦХ ХК) нь нийт 15 уран сайхны кино бүртгүүлсэн бөгөөд эдгээр нь ОСДҮЭ-ийн нийт бүртгүүлсэн 74 бүтээлийн 20%-ийг эзэлж байгаа ба бүртгүүлсэн бүх бүтээлийн эрхийн гэрээ хугацаагүйгээр байгуулагдсан байна.
- Ори медиа ХХК нь хамгийн олон буюу 51 бүтээлийн мэдээлэл бүртгүүлсэн бөгөөд нийт бүртгэгдсэн ОСДҮЭ дотоод бүтээлийн 69%-ийг бүрдүүлжээ. Эдгээрийн дотроос 49 нь уран сайхны кино, 2 нь олон ангит киноны төрөлд хамаарч байна.


Эдгээр тоон үзүүлэлтүүдээс харахад, үйлчилгээ эрхлэгчид дотоод контентын бүртгэл, эрхийн мэдээллийг системд оруулах үйл ажиллагаанд идэвхтэй хамрагдаж байгаа бөгөөд голчлон уран сайхны кино төрөлд төвлөрч буй нь анзаарагдаж байна.



ГАДААД БҮТЭЭЛ:

Системд гадаад бүтээлийн мэдээлэл бүртгүүлсэн нийт 18 байгууллагаас 5 нь ОСДҮЭ байна. Энэ нь гадаад бүтээл бүртгүүлсэн нийт байгууллагын 28%-ийг эзэлж байна. Эдгээр 5 ОСДҮЭ-ээс нийт 628 гадаад бүтээлийн мэдээлэл бүртгүүлсэн нь системд бүртгэгдсэн нийт бүтээлийн (1603 бүтээл) 39%-ийг бүрдүүлж байгаа бөгөөд дотоод бүтээлийн тоотой харьцуулахад 88%-иар өндөр үзүүлэлттэй байна.

График-2. ОСДҮЭ нэг бүрийн оруулсан гадаад бүтээлийн мэдээллийг нийт ОСДҮЭ-ийн оруулсан бүтээлийн тоонд харьцуулсан тоон мэдээлэл.



Дээрх графикаас үзэхэд, ОСДҮЭ-ийн дундаас Мобинет ХХК нь системд хамгийн олон гадаад бүтээлийн мэдээлэл (нийт 279 бүтээл) бүртгүүлсэн байгууллага бөгөөд энэ нь нийт ОСДҮЭ-ийн бүртгүүлсэн бүтээлийн 45.3%-ийг эзэлж байна. Харин Монголын цахилгаан холбоо ХК нь 5 бүтээлийн мэдээлэл бүртгүүлсэн нь нийт бүртгэгдсэн бүтээлийн 0.7%-ийг бүрдүүлж байна.

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид бүртгүүлсэн бүх гадаад бүтээлээ дистрибьютер байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр дамжуулж байгаа бөгөөд гэрээ байгуулсан байгууллагаар нь авч үзэхэд Филмбриж ХХК-иас авсан гадаадын бүтээлүүд хамгийн их буюу 226 бүртгэгдсэн нь ОСДҮЭ-ийн оруулсан нийт гадаад бүтээлийн 36%-ийг эзэлж байна. Харин МЦХ ХК нь Монголсат нэтворкс ХХК-иас 5 гадаадын бүтээл авч дамжуулж байгаа нь хамгийн бага хувийг эзэлж байна.


ГАДААД СУВАГ:

Системд бүртгэгдсэн 5 олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн 26 орны нийт 209 гадаадын телевизийн сувгаас "Юнивишн" ХХК нь 80 сувгийг бүртгүүлсэн нь хамгийн их хувийг эзэлж, нийт сувгийн 39%-ийг бүрдүүлж байна. Харин хамгийн бага бүртгэлтэй нь "Монголын цахилгаан холбоо" ХК бөгөөд тус байгууллага ердөө 5 гадаадын телевизийн суваг бүртгүүлсэн нь нийт бүртгэлийн 2%-ийг эзэлж байна.

Хүснэгт-3. ОСДҮЭ бүртгүүлсэн гадаад сувгийн мэдээллийг харьяалах улсаар нь ангилсан тоон мэдээлэл.

№	Харъяа улс	Үйлчилгээ эрхлэгчийн нэр					Нийт
		Ддэш ТВ ХХК	МЦХ ХК	Сансар дижитал ХХК	Эн Би Си ХХК	Юнивишн ХХК	
1	АНУ	11			2	7	20
2	Австрали				1	1	2
3	Австри					1	1
4	Болгар	1			3	1	5
5	Вьетнам					1	1
6	Герман	1		1	1	2	5
7	Испани			1			1
8	Итали				1		1
9	Их Британи	3			3	5	11
10	Казахстан	4		1	3	3	11
11	Канад	1				3	4
12	Катар				1		1
13	Киргиз		5				5
14	Люксембург					1	1
15	ОХУ	7		9	22	17	55
16	Өвөр монгол			1		1	2
17	Сингапур	12		1	1	21	35
18	Словак	1				1	2
19	БНСУ	2		2		3	7
20	Тайланд				2	2	4
21	Турк				1		1
22	Украин					2	2
23	Франц	4		3	4	3	14
24	БНХАУ	3		4	2	3	12
25	Чех				1		1
26	Япон	1		1	1	2	5
Нийт		51	5	24	49	80	209

График-3. ОСДҮЭ нэг бүрийн оруулсан гадаад сувгийн мэдээллийг нийт ОСДҮЭ-ийн бүртгүүлсэн гадаад сувгийн тоонд харьцуулан хувиар илэрхийлэв.




Хүснэгт 3-аас үзэхэд ОХУ-ын телевизийн суваг 55 бүртгэгдсэн нь хамгийн их хувийг эзэлж, нийт сувгийн 26%-ийг бүрдүүлж байна. Харин Австри, Вьетнам,

Испани, Итали, Катар, Люксембург, Турк, Чех улсуудын телевизийн суваг тус бүр 1 бүртгэгдсэн нь хамгийн бага хувийг эзэлж байна.


Үүнээс Эн Би Си ХХК нь хамгийн олон буюу 22 ОХУ-ын телевизийн суваг бүртгүүлсэн нь нийт бүртгэгдсэн ОХУ-ын сувгийн 40%-ийг эзэлж байна. Харин Ддэш ТВ ХХК нь 7 суваг бүртгүүлсэн нь нийт ОХУ-ын сувагтай харьцуулахад хамгийн бага буюу 12%-ийг бүрдүүлсэн үзүүлэлттэй байна.

График-3. Системд бүртгэгдсэн гадаадын телевизийн сувгийг харьяалагдах улсаар ангилж хувиар илэрхийлэв.



Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн системд бүртгүүлсэн гадаад сувгийн мэдээллийг хөтөлбөрийн төрөл, чиглэлээр нь авч үзэхэд 20 төрлийн хөтөлбөртэй гадаад сувгууд бүртгэгдсэнээс олон талт хөтөлбөртэй телевизийн сувгууд 46 бүртгэгдсэн нь хамгийн их хувийг эзэлж, нийд гадаад сувгийн 22%-ийг бүрдүүлж байна. Харин ан агнуур болон теле худалдааны телевизийн суваг тус бүр 1 бүртгэгдсэн нь хамгийн бага хувийг эзэлж байна.

График-3. Системд бүртгэгдсэн гадаадын телевизийн сувгийг хөтөлбөрийн төрлөөр нь ангилж хувиар илэрхийлэв (хамгийн өндөр хувьтай 10 төрөл).



5. Дүгнэлт

“Телевиз, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй бүтээлийн жагсаалтыг ил, тод нээлттэй байршуулах дундын нэгдсэн систем”-д бүтээл оруулсан нийт 45 үйлчилгээ эрхлэгч байгаа бөгөөд үүнийг системд бүртгэлтэй бүтээлийн мэдээллээ оруулах шаардлагатай үйлчилгээ эрхлэгчийн тоонд харьцуулахад 32% (ОСДҮЭ-10, ӨНТВ-24, Арилжааны ТВ-11)-ийг эзэлж байна.

Тайлангаас харахад үйлчилгээ эрхлэгчид нь шинээр бүтээл оруулах мөн бүтээлийг тухай бүр шинэчлэн оруулах нь харьцангуй бага байна. Иймд 2025 оны 1-р улиралд үйлчилгээ эрхлэгчдээс тус системийн хэрэглээ, ач холбогдол болон хэрхэн сайжруулж хэрэглээг нэмэгдүүлэх талаар санал асуулга авсны дагуу үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөмж хүргүүлэн ажиллав.

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРОО
2025 ОН